

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ

БАРИМТЫН АШИГЛАЛТЫН ХУУДАС

Данс, бүртгэлийн дугаар _____

Хадгаламжийн нэгжийн дугаар _____

Хадгаламжийн нэгжийн гарчиг _____

Ашиглалтанд олгосон он, сар, өдөр	Хэнд олгосон /овог, нэр/	Ашиглалтын хэлбэр /хуулбар, хэсэгчилсэн хуулбар, үзэж судлах /	Ашигласан хуудасны дугаар	Хэрэглэгчийн гарын үсэг
1	2	3	4	5

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Н.Мандах* Ц.ЭНХМАНДАХ

2025 оны 02 дугаар сарын .19

Дотоод товьёг

Д/д	Баримтын индекс	Баримтын он, сар, өдөр	Баримтын тэргүү	Баримтын хуудасны дугаар	Тайлбар
1	2	3	4		6
2	A/01	2024.01.05	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай	1-4	
3	A/02	2024.01.08	Бизнес төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай	5	
4	A/03	2024.01.08	Ажлын хэсэг байгуулах тухай Хөрөнгө түрээслүүлэх	6	
5	A/04	2024.01.08	Ажил хүлээлцэх байнгын комиссыг шинэчлэн байгуулах тухай	7	
6	A/05	2024.01.08	Байгууллагы өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай	8-11	
7	A/06	2024.01.15	Байгууллагын "Баримт бичиг нягтлан шалгах комисс"-ыг шинэчлэн байгуулах тухай	12	
8	A/07	2024.01.16	Хөрөнгө хүлээлцэх ажлыг хэсэг байгуулах тухай	13	
9	A/08	2024.01.16	Биеийн тамир, спорт хамтлаг шинэчлэн байгуулах тухай	14-15	
10	A/09	2024.03.12	Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай	16	
11	A/10	2024.04.01	Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	17-19	
12	A/11	2024.04.10	Залуучуудын хөгжлийн зөвлөл шинэчлэн байгуулах тухай	20-21	
13	A/12	2024.04.20	"Монгол хүү 2024" хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах тухай	22-28	
14	A/13	2024.05.01	Ажилтан, албан хаагчдад олгох унаа хоолны хөнгөлөлтийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	29	
15	A/14	2024.05.13	Ажлын хэсэг байгуулах тухай /Үйлчилгээний ажлыг зохион байгуулах/	30	
16	A/15	2024.06.19	Ажилтан, албан хаагчдад олгох унаа, хоолны	31	

			хөнгөлөлтийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай		
17	A/16	2024.06.20	Тооллогын комисс байгуулах тухай	32	
18	A/17				
19	A/18	2024.07.25	Бараа материалыг данснаас хасах тухай	33-38	
20	A/19	2024.08.20	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай	39-40	
21	A/20	2024.08.26	Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө батлах тухай	41-43	
22	A/21	2024.08.26	Хөрөнгө хүлээлцэх ажлын хэсэг байгуулах	44-45	
23	A/22	2024.09.20	Айрагны баяр-2024 арга хэмжээг зохион байгуулах тухай	46-49	
24	A/23	2024.10.21	Ажлын хэсэг байгуулах тухай	50-51	
25	A/24	2024.12.05	Тооллогын комисс байгуулах тухай	52	
26	A/25	2024.12.10	"Эрүүл иргэн эко хөгжил" арга хэмжээ зохион байгуулах тухай	53-56	

Дүн тоо: 25 (хорин тав) баримт бичиг бүртгэв.
(тоо, үсгээр)

Дотоод товъёгны хуудасны тоо 2 (хоёр)
(тоо, үсгээр)

Дотоод товъёг үйлдсэн:
Архив, бичиг хэрэг хариуцсан
Мэргэжилтэн *Д.Михайлаха* Ц.Энхмандах

2025 он 02 сар 19 өдөр



**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

**Ээлжийн амралтын хуваарь
батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл, Хөдөлмөр хамгааллын сайдын 2021 оны А/91 дүгээр тушаал, Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчдын 2024 оны ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын үед ажлыг орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох ажилтанд хүлээлгэн өгч баталгаажуулах, батлагдсан хуваарь, ээлжийн амралтын хугацаанд хяналт тавьж ажиллахыг хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Г.Мөнгөнзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА,



С.САЙНБАЯР



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 4/02.

Улаанбаатар хот

Бизнес төлөвлөгөө боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4, 4 дүгээр зүйлийн 4.10.6 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын 2024 оны бизнес төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Отгонбаяр

(Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал)

Гишүүд :

Н.Буянхишиг

(Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал)

С.Отгонгэрэл

(Хуулийн зөвлөх)

Нарийн бичгийн дарга:

М.Сувдгэрэл

(Нярав)

2.Бизнес төлөвлөгөөг зах зээлийн судалгаанд үндэслэн 2024 оны зорилго, зорилтууд, хүрэх үр дүнг тодорхойлон танилцуулахыг Ажлын хэсэг (Н.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.САЙНБАЯР



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Энэ онд тэгш ой нь тохиож байгаа аймаг сумдуудын наадамд хөрөнгө түрээслүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Төмөрбаатар
(Захиргаа, удирдлагын албаны захирал)

Гишүүд :

Н.Отгонбаяр
(Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал)
Н.Буянхишиг
(Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал)
Г.Дөлгөөн
(Тохижилт, үйлчилгээний албаны захирал)
С.Отгонгэрэл
(Хуулийн зөвлөх)

Д.Дашдаваа
(Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

О.Анхбаяр
(Мэдээлэл технологи, цахимжуулалт хариуцсан мэргэжилтэн)

2.Уг ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Төмөрбаатар) -т үүрэг болгосугай.

ДАРГА



С.САЙНБАЯР



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар АНУ

Улаанбаатар хот

Ажил, хүлээлцэх байнгын комиссыг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.10.6, 6 дугаар хэсгийн 6.2, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дахь хэсгийн 3.4, 14 дэх хэсгийн 14.3.4 дэхь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус байгууллагад томилогдсон ажилтны ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь шаардагдах нөхцөл, техник тоног төхөөрөмжөөр хангах, ажлаас чөлөөлөгдөхөд ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон бусад төлбөр тооцоог барагдуулан ажил хүлээлцүүлж байх үүрэг бүхий байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Комиссын дарга:

Гишүүд:

Захиргаа, удирдлагын албаны захирал

Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал

Ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн зөвлөх

Хүний нөөцийн мэргэжилтэн

Архив, бичиг хэргийн ажилтан

Нарийн бичиг:

Нярав

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох журмын дагуу ажлыг хүлээлцүүлж, байгууллагын удирдлагад тухай бүр танилцуулж ажиллахыг ажлын комиссын дарга Захиргаа удирдлагын албаны захирал (Д.Төмөрбаатар)-д даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын Даргын 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.САЙНБАЯР



**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

**Байгууллагын өмч хамгаалах байнгын
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, 31.3.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/156 дугаар захирамж, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Захиргаа удирдлагын албаны захирал

Гишүүд:

Ерөнхий инженер

Ахлах мэргэжилтэн бөгөөд ашиглалтын инженер

Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ерөнхий нягтлан бодогч

2.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.

3.Байгууллагын өмчийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын хэвийн байдал, хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавьж, холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэр гаргаж ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн тогтоох тухай” А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




С.САЙНБАЯР

D:\2024\Тушаалын төсөл

1753301005

"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын
даргын 2024 оны 01 сарын 08 өдрийн
1/05 тоот тушаалын хавсралт

ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ



Нэг. Үндэслэл

1.1.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын эзэмшилд байгаа эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт, түрээслэх, шилжүүлэх, актлах болон шинээр эд хөрөнгө худалдан авахтай холбоотой харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу өмч хамгаалах зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд баримтлах зарчим, эрх, үүргийг тодорхойлоход оршино.

1.2.Өмч хамгаалах зөвлөл нь орон тооны бус, байнгын үйл ажиллагаатай байна.

1.3.Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

Хоёр. Өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулах

2.1."Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн /цаашид зөвлөл гэнэ/ үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн зөвлөлийг байгууллагын даргын шийдвэрээр байгуулна.

2.3.Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллана.

2.4.Өмч хамгаалах байнгын зөвлөл нь дотоод хяналт хийх болон байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой дүгнэлт гаргах, хууль, тогтоомж, журам тухайн байгууллага дээр хэрхэн хэрэгжиж буйд хяналт тавина.

Гурав. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах зарчим

3.1.Байнгын зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн ашиглалт хамгаалалт, эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах асуудлаар холбогдох журам, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр болон энэхүү Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон дүгнэлт, шийдвэрийг хурлын тэмдэглэл хэлбэрээр гаргаж ажиллана.

Дөрөв. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн эрх, үүрэг

4.1.Байнгын зөвлөл нь байгууллагынхаа өмч хөрөнгийг зөв зохистой, ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж, өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомжийг сурталчлах, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт,

хамгаалалтыг сайжруулах талаар байгууллагаас зохиож буй ажил, түүний хэрэгжилт, гаргаж буй шийдвэрт хяналт тавина.

4.2. Байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгө хуримтлагдсан элэгдлээр анхны үнээ нөхсөн, түүнчлэн эвдэрч засвар авахгүй улмаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон, техник технологийн хоцрогдолд орсон үл хөдлөх болон үндсэн хөрөнгийг шилжүүлэх, акталж устгах, зориулалтыг өөрчлөх, үнэ тогтоох, худалдах зэрэг ажиллагааг хэлэлцэн баталсан журмын дагуу санал, дүгнэлт гаргана.

4.3. Байгууллагын хагас жилийн болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавьж, дүгнэлт өгнө. Шаардлагатай гэж үзвэл хяналтын тооллого хийж болно.

4.4. Эд хөрөнгийн тооллого, бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд тавих дотоод хяналт, шалгалтыг дотоод алба нэгжтэйгээ хамтран зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтээ удирдлагад танилцуулж эрх бүхий дээд байгууллагад хүргүүлнэ.

4.5. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь эд хөрөнгө актлах, шилжүүлэх, устгах талаархи дүгнэлт, комиссын шийдвэрийг байгууллагын даргад танилцуулан тушаалаар баталгаажуулна.

4.6. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах бол үндэслэл, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргах

4.7. Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжид их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт хяналт тавих ?

4.8. Эвдэрсэн, гэмтсэн, чанар, байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон, тухайн үеийн зах зээлийн үнийн жишиг ханшнаас хэт өндөр үнээр авсан хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгийг илрүүлж, буруутай этгээдээр хохирлыг арилгуулах, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авахыг байгууллагын даргаас шаардах эрхтэй. ?

4.9. Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс актлахаар шийдвэрлэсэн эд хөрөнгө, бараа материалыг устгах шийдвэр гарган байгууллагын даргад саналаа уламжилж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.

4.10. Эд хөрөнгө тооллогын дүнгээр дутагдсан, маргаантай, илүүдэлтэй, ашигладаггүй хөрөнгийн шалтгааныг тогтоох

4.11. Удирдлагад хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, тухайн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж өгөх

4.12. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь эд хөрөнгө шилжүүлэх, актлах шийдвэрээ тухай бүр байгууллагын даргад танилцуулна.

4.13. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах, түрээсийн хөрөнгийн ашиглалт, чанар байдалд хяналт тавьж ажиллана.

4.14. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгө, бараа материал актлах саналаа жил бүрийн 1, 7 дугаар сард багтаан ирүүлж байх

4.15. Төрийн өмчийг үрэгдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ авах, зөрчил гаргасан этгээдтэй хариуцлага тооцох асуудлыг байгууллагын дотоод журам, бусад хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлүүлэх саналыг удирдлагад хүргүүлнэ.

Тав. Зөвлөлийн хурал

5.1.Байнгын зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлын талаар дүгнэлт гаргаж, хийсэн ажлынхаа талаар тайлан гаргаж байгууллагын даргад танилцуулна.

5.2.Байнгын зөвлөл нь хагас жилд 2 удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлаж болно.

5.3.Байнгын зөвлөлийн дарга хурлыг товлож, нарийн бичгийн даргаар дамжуулан бусад гишүүдэд зарлана.

5.4.Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд гишүүдийн ирц 50-аас дээш хувьтай тохиолдолд хүчин төгөлдөр болно. Даргын эзгүйд ажлаа орлуулсан гишүүн удирдана.

5.5.Хурлаар хэлэлцэгдэх асуудал дараах зарчмаар боловсруулагдсан байна.Үүнд:

- Танилцуулга
- Үндэслэл
- Дүгнэлт

5.6.Хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:

- а) Хэлэлцэх асуудлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга танилцуулна.
- б) Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, хариулт
- с) Зөвлөлийн гишүүдийн санал
- д) Хурлын даргаас хэлэлцэж буй асуудлын талаар гаргах дүгнэлтийн төсөл танилцуулах
- е) Дүгнэлтийг санал хурааж батлах

5.7.Зөвлөлийн хурлын дүгнэлт, шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болж байгууллагын даргын тушаалаар баталгаажна.

5.8.Хурлын тэмдэглэлийг 2 хувь үйлдэнэ.

5.9.Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй болсон гишүүн саналыг бичгээр авч болно.

5.10.Зөвлөлийн хурлын ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, жилийн эцэст гишүүн бүрээр хуралд оролцсон байдал, гаргасан санал, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулна.

5.11.Зөвлөлийн хурлыг өргөтгөсөн хэлбэрээр буюу ажилтан, албан хаагчдыг оролцуулан хуралдуулж болно.

5.12.Зөвлөлийн хурлын шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэрээр гарна.

Зургаа: Хүлээх хариуцлага

6.1.Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасан хариуцлага хүлээнэ.

6.2.Хууль тогтоомж зөрчигсдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Үндсэн хөрөнгө данснаас хасах, шилжүүлэх, худалдах, шинээр олж авах, бүртгэх журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/06.

Улаанбаатар хот

Байгууллагын “Баримт бичиг нягтлан
шалгах комисс”-ыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг нягтлан шалгах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга:

Тогтоол шийдвэр, дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал
Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал
Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг:

Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн

2.Баримт бичиг нягтлан шалгах комисст холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллахыг даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын албаны захирал (Д.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын Даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.САЙНБАЯР

D:\2024\Тушаалын төсөл

1760301006



**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А07

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээлцэх ажлын хэсэг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/556 дугаар тушаал, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яамнаас Нийслэлийн өмчлөлд блансаас блансад шилжүүлсэн тайз, иж бүрдэл тоног төхөөрөмжийг хүлээлцэх нөхцөл боломжийг хангах шуурхай зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Төмөрбаатар
(Захиргаа, удирдлагын албаны захирал)

Гишүүд:

Н.Отгонбаяр
(Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал)

С.Отгонгэрэл
(Ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн зөвлөх)

Д.Дашдаваа
(Соёл спорт хариуцсан мэргэжилтэн)

М.Цэцэгмаа
(Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

М.Сувдгэрэл
(Нярав)

2. Хөрөнгө хүлээлцэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах нөхцөл боломжийг хангах, ажлыг шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Д.Төмөрбаатар)-т даалгасугай.

ДАРГА



С.САЙНБАЯР

D:\2024\Тушаалын төсөл

1786301007



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Биеийн тамир, спорт хамтлаг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Биеийн тамир спортын газрын даргын 2017 оны А/82 дугаар тушаал “Биеийн тамир спортын хамтлаг байгуулах дүрэм”, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын албан хаагчдын дунд биеийн тамир спортыг сурталчлах, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах биеийн тамир спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тэдний идэвх сонирхлыг дэмжиж, биеийн тамир спортын хамтлагийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж хавсралтаар баталсугай.

2.Албан хаагчдын дунд биеийн тамир спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах, Нийслэлийн засаг даргын нэрэмжит нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын наадамд оролцох төлөвлөгөөг батлуулж, уралдаан тэмцээний удирдамж дүрмийг тухай бүр байгууллагын шуурхай хурлаар хэлэлцүүлэн тайлан мэдээг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг спорт хамтлагийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Биеийн тамир спортын арга хэмжээнд шаардагдах зардлыг тухай бүрд нь төсөв гарган батлуулж, холбогдох зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Буянхишиг)-т зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын албаны захирал (Д.Төмөрбаатар)-д даалгасугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын Даргын 2022 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн А/17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




С.САЙНБАЯР

D:\2024\Тушаалын төсөл

1766391602

"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын
даргын /Х.Х./-ны /О./ дугаар сарын /Б./ ны
өдрийн /Б./ дугаар тушаалын хавсралт



СПОРТ ХАМТЛАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Гүйцэтгэх үүрэг	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
1	Хамтлагийн дарга:	Тохижилт, үйлчилгээний албаны захирал	Хамтлагийн төлөвлөгөөг боловсруулах, тэмцээн уралдаан зохион байгуулахад удирдлага манлайлал үзүүлж ажиллах
2	Гишүүд:	Хамтын ажиллагаа, гэрээ хариуцсан мэргэжилтэн	Төлөвлөгөөнд санал оруулах, хэрэгжүүлэх, тэмцээн уралдаан зохион байгуулах
3		Архив, бичиг хэргийн ажилтан	
4		Ахлах харуул	
5	Нарийн бичиг:	Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн	Удирдамж боловсруулах, тайлан ирүүлэх

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дэргэдэх төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны
дарга:

Д.Төмөрбаатар
(Захиргаа, удирдлагын албаны захирал)

Гишүүд:

Н.Отгонбаяр
(Маркетинг хамтын ажиллагааны албаны захирал)
С.Отгонгэрэл
(Ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн зөвлөх)
Ч.Чонцолдулам
(Тогооч)

Нарийн бичгийн дарга:

Г.Мөнгөнзул
(Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн)

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн А/27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.САЙНБАЯР



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар АИО

Улаанбаатар хот

Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4,10,5, 4,10,6 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг ажилтан, албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Шинэчлэн тогтоосон цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож, холбогдох журмын дагуу бодож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Буянхишиг)-т зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын албаны Захирал (Д.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай” А/23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.САЙНБАЯР

"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын
Даргын 2024 оны 04 сарын 04 өдрийн
Анхдугаар тушаалын хавсралт

"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН АЛБАН ТУШААЛЫН
ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ЖАГСААЛТ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын ангилал зэрэглэл	Хүний тоо	Үндсэн цалингийн хэмжээ
1	2	3	4	5
1	Захиргаа, удирдлагын албаны захирал	ТҮ-10	1	1,543,000
2	Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал бөгөөд ерөнхий нягтлан бодогч	ТҮМ-8	1	1,544,000
3	Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал	ТҮ-10	1	1,543,000
4	Тохижилт, үйлчилгээний албаны захирал	ТҮ-10	1	1,543,000
5	Ерөнхий инженер	ТҮ-9	1	1,470,000
6	Эдийн засагч	ТҮ-8	1	1,337,000
7	Хуулийн зөвлөх бөгөөд ахлах мэргэжилтэн		1	
8	Хяналт-шинэжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн		1	
9	Ашиглалтын инженер		1	
10	Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	ТҮ-7	1	1,264,000
11	Мэдээлэл технологи цахимжуулалт хариуцсан мэргэжилтэн		1	
12	Архитектор		1	
13	Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн		1	
14	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн		1	
15	Хамтын ажиллагаа, гэрээ хариуцсан мэргэжилтэн		1	
16	Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн		1	
17	Тогтоол, шийдвэр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн		1	
18	Нярав	ТҮ-4	1	1,042,000
19	Жолооч	ТҮ-3	3	992,000
20	Ахлах тогооч	ТҮ-3	1	
21	Цахилгаанчин		2	
22	Сантехникч		2	
23	Ахлах харуул		1	

24	Галч бөгөөд тохижилт үйлчилгээний ажилтан	TY-2	4	946,000
25	Тогооч		1	
26	Тохижилт үйлчилгээний ажилтан	TY-1	4	900,000
27	Харуул		2	



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Залуучуудын хөгжлийн зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4.2, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 4 дүгээр тогтоол, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.5, 4.10.6 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хамгаалах шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлэх, үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн ажиллах зорилгоор тус зөвлөлийг шинэчлэн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Н.Буянхишиг
(Санхүү, хөрөнгө оруулалтын албаны захирал)

Дэд дарга:

Г.Мөнгөнзул
(Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

М.Сувдгэрэл
(Нярав)
М.Цэцэгмаа
(Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн)
И.Пүрэвжав
(Тогтоол шийдвэр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)
Д.Дашдаваа
(Соёл, спорт хариуцсан хариуцсан мэргэжилтэн)
Б.Хулан
(Архитектор)
Ц.Энхмандах
(Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн)
Ч.Чонцолдулам
(Ахлах тогооч)
Ч.Цогбадрах
(Жолооч)

Нарийн бичгийн дарга:

С.Гантогтох
(Хамтын ажиллагаа гэрээ хариуцсан мэргэжилтэн)

2.Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулах, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн дарга (Н.Буянхишиг)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын албаны захирал (Д.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



С.САЙНБАЯР



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/12.

Улаанбаатар хот

“Монгол хүү-2024” хүүхдийн баярын
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний А/437 дугаар захирамж, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 1.1.1, 4.10.2, 4.10.6 дугаар зүйл заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-аас санаачлан хэрэгжүүлж буй “Монгол хүү 2024” хүүхдийн баярын арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Хүй долоо худагт зохион байгуулсугай.

2.“Монгол хүү 2024” хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, хөтөлбөрийг 3 дугаар хавсралтаар, хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Хүүхдийн баярын үйл ажиллагааны арга хэмжээний зардлыг холбогдох бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Буянхишиг)-д зөвшөөрсүгэй.

4.Хөтөлбөрийг иргэд олон нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал (Н.Отгонбаяр)-д, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын албаны захирал (Д.Төмөрбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.САЙНБАЯР

"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын
даргын 2024 оны ~~04~~ сарын ~~20~~ ны өдрийн
4/12 дугаар тушаалын 1 -р хавсралт



"Монгол хүү-2024" хүүхдийн баярын арга хэмжээ
зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга
захирал /

Н.Отгонбаяр /Маркетинг, хамтын ажиллагааны

Гишүүд

Д.Төмөрбаатар /Захиргаа, удирдлагын албаны захирал/
Г.Дөлгөөн /Тохижилт, үйлчилгээний албаны захирал/
Н.Булдхишиг /Санхүү, хөрөнгө оруулалтын
албаны захирал/
Б.Хулан /Архитектур/
И.Пүрэвжав /Дотоод ажил, тогтоол шийдвэр хариуцсан
мэргэжилтэн/
Д.Дашдаваа /Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн/
М.Цэцэгмаа /Хэвлэл мэдээлэл, олон нийттэй
харилцах мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга:

С.Гантогтох /Хамтын ажиллагаа, гэрээ
хариуцсан мэргэжилтэн/

"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын
даргын 2024 оны 04 сарын 20-ны өдрийн
А/12 дугаар тушаалын 2-р хавсралт



**"МОНГОЛ ХҮҮ-2024" ОЛОН УЛСЫН ҮНДЭСНИЙ ХҮҮХДИЙН БАЯРЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024 оны 05 дугаар сарын 06

№	Хариуцах ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх байгууллага, хувь хүн
Нэг. Бэлтгэл ажил				
1.1	"Монгол хүү - 2024" олон улсын хүүхдийн баярыг зохион байгуулах, нэгдсэн бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулах;	III/07-III/25	Маркетинг, хамтын ажиллагааны алба	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын нийт ажилчид
1.2	"Монгол хүү-2024" олон улсын хүүхдийн баярыг зохион байгуулахад шаардагдах төсөв гарган танилцуулах	III/25-V/25	Маркетинг, хамтын ажиллагааны алба, Санхүү хөрөнгө оруулалтын алба	Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал Н.Отгонбаяр Санхүү хөрөнгө оруулалтын албаны захирал бөгөөд ерөнхий нягтлан бодогч Н.Булдиршинг
1.3	"Монгол хүү-2024" олон улсын хүүхдийн баярыг зохион байгуулах талбайн зураг гарган танилцуулах, батлуулах	III/18-V/25	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Архитектур Б.Хулан
1.4	Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, холбоодыг "Монгол хүү-2024" олон улсын хүүхдийн баярын арга хэмжээнд татан оролцуулах, санал тавих	III/20-IV/05	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Монголын хүүхдийн ордон
1.5	Түрээсийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудтай түрээсийн гэрээ байгуулах	III/15-V/15	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал Н.Отгонбаяр Мэргэжилтэн С.Гантогтох
1.6	Талбайн тохижилтыг батлагдсан зургийн дагуу хийж гүйцэтгэх /Тайз, асар майхан, сандал, туг далбаа, хогийн сав гэх мэт/	V/24-V/25	Тохижилт үйлчилгээний алба	Тохижилт үйлчилгээний албаны ажилчид
1.7	Талбайд шаардлагатай цахилгаан хангамжийн асуудлыг хийж гүйцэтгэх	IV/18-V/25	Тохижилт үйлчилгээний алба	УБЦТС ТӨХК
1.8	Хүүхдийн баярын бүх төрлийн эх бэлтгэл, хэвлэлтийг хариуцан ажиллах	III/15-V/25	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Цэцэгмаа Хулан
1.9	"Монгол хүү-2024" олон улсын хүүхдийн баярын нээлт хаалт, тайзны арга хэмжээ урлагийн тоглолтын бэлтгэл ажлыг ханган ажиллах	IV/15-V/25	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Монгол улсын хүүхдийн ордон
1.10	Арга хэмжээний үеэр хэв журам, онцгой байдал, түргэн, аюулгүй байдлын асуудлыг зохицуулах бэлтгэл ажлыг хангах	III/18-V/25	Тохижилт үйлчилгээний алба	Цагдаагийн ерөнхий газрын хэв журмын тасаг

1.11	Нойл, ариун цэврийн үйлчилгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах /нойлын үйл ажиллагааг жигдрүүлэх, цэвэр ус дүүргэх, бохир соруулах машин бэлтгэх, нойл хариуцан ажиллах амьтныг томилох гэх мэт/	III/18-V/25	Тохижилт үйлчилгээний алба	Тохижилт үйлчилгээний албаны үйлчлэгчид
1.12	Баярын арга хэмжээнд хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүнс, худалдаа, үйлчилгээний чиглэлийн байгууллагуудад сандал тээвэр, тэтгэн оролцуулах	V/01 дотор	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал Н.Отгонбаяр Мэргэжилтэн С.Гантогтох
Хоёр. Зохион байгуулагдах арга хэмжээ				
2.1	Нээлтийн үйл ажиллагаа	V/31-VI/01	Д.Дашдаваа	Хамтран зохион байгуулагч байгууллагууд
2.2	Хүүхдийн урлагийн тоглолт	V/31-VI/01	Д.Дашдаваа	Монгол улсын хүүхдийн ордон
УРЛАГИЙН ХЭСЭГ				
2.3	Хүүхэлдэйн театр	V/31-VI/01	Д.Дашдаваа	Монголын хүүхдийн ордон
2.4	Циркийн үзүүлбэр	V/31-VI/01		Цирк
2.5	Үлгэрийн баатрууд	V/31-VI/01		
Хөгжөөнт тоглоомны хэсэг				
2.6	Тэмээ, цаа буга унах /Урц/	V/31-VI/01	Н.Отгонбаяр	Хувь хүн
2.7	Морь уналага	V/31-VI/01	Х.Өрнөхбаяр	
2.8	Хүүхдийн машин унах	V/31-VI/01	Н.Отгонбаяр	
2.9	Хүүхдийн тоглоомын талбай /гулгуур, усан сан гэх мэт/	V/31-VI/01	Зохион байгуулах ажлын хэсэг	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
2.10	Дартсны тоглоом	V/31-VI/01	С.Гантогтох	Эрчим дартсын клуб
2.11	Усан завь	V/31-VI/01		
2.12	Амьтны хүрээлэн	V/31-VI/01	Энх-мандах	Улаанбаатар зоо
СПОРТЫН ХЭСЭГ				
2.13	Хүүхдийн Үндэсний бөхийн барилдаан /насны ангиллаар/	V/31-VI/01	Н.Отгонбаяр	Хуйрнан шуугигч 2024
2.14	Зээрэнцэг, бөмбөг шидэх	V/31-VI/01	С.Гантогтох	Холбоо
2.15	3х3 хүүхдийн сагсан бөмбөгийн тэмцээн /гэр бүлийн насны ангиллаар/	V/31-VI/01	С.Гантогтох	Маркетинг хамтын ажиллагааны албаны мэргэжилтэн С.Гантогтох
2.16	Хүүхдийн сур харвааны тэмцээн /насны ангиллаар/	V/31-VI/01	Н.Отгонбаяр	Харваачдын холбоо
2.17	Унадаг дугуйн уралдаан /насны ангиллаар/	V/31-VI/01	И.Пүрэвжав	Монголын дугуйн холбоо
2.18	Хүүхдийн уралдаан	V/31-VI/01	Н.Отгонбаяр	Хангарьд
2.19	Морины зүс таних тэмцээн	V/31-VI/01	Х.Өрнөхбаяр	
2.20	Таеквондо хэсэг	V/31-VI/01	Цэцэгмаа	Нүүдэлчин монгол

1.11	Нойл, ариун цэврийн үйлчилгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах /нойлын үйл ажиллагааг жигдрүүлэх, цэвэр ус дүүргэх, бохир соруулах машин бэлтгэх, нойл хариуцан ажиллах амьттан томилох гэх мэт/	III/18-V/25	Тохижилт үйлчилгээний алба	Тохижилт үйлчилгээний албаны үйлчлэгчид
1.12	Баярын арга хэмжээнд хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүнс, худалдаа, үйлчилгээний чиглэлийн байгууллагуудад санал тавих, тэтгэл оролцуулах	V/01 дотор	Маркетинг, хамтын ажиллагааны алба	Маркетинг, хамтын ажиллагааны албаны захирал Н.Отгонбаяр Мэргэжилтэн С.Гантогтох
Хоёр. Зохион байгуулагдах арга хэмжээ				
2.1	Нээлтийн үйл ажиллагаа	V/31-VI/01	Д.Дашдаваа	Хамтран зохион байгуулагч байгууллагууд
2.2	Хүүхдийн урлагийн тоглолт	V/31-VI/01	Д.Дашдаваа	Монгол улсын хүүхдийн ордон
УРЛАГИЙН ХЭСЭГ				
2.3	Хүүхэлдэйн театр	V/31-VI/01	Д.Дашдаваа	Монголын хүүхдийн ордон
2.4	Циркийн үзүүлбэр	V/31-VI/01		Цирк
2.5	Үлгэрийн баатрууд	V/31-VI/01		
Хөгжөөнт тоглоомны хэсэг				
2.6	Тэмээ, цаа буга унах /Урц/	V/31-VI/01	Н.Отгонбаяр	Хувь хүн
2.7	Морь уналага	V/31-VI/01	Х.Өрнөхбаяр	
2.8	Хүүхдийн машин унах	V/31-VI/01	Н.Отгонбаяр	
2.9	Хүүхдийн тоглоомын талбай /гулгуур, усан сан гэх мэт/	V/31-VI/01	Зохион байгуулах ажлын хэсэг	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
2.10	Дартсны тоглоом	V/31-VI/01	С.Гантогтох	Эрчим дартсын клуб
2.11	Усан саарь	V/31-VI/01		
2.12	Амьтны хүрээлэн	V/31-VI/01	Энх-мандах	Улаанбаатар зоо
СПОРТЫН ХЭСЭГ				
2.13	Хүүхдийн Үндэсний бөхийн барилдаан /насны ангиллаар/	V/31-VI/01	Н.Отгонбаяр	Хуйрнан шуугигч 2024
2.14	Зээрэнцэг, бөмбөг шидэх	V/31-VI/01	С.Гантогтох	Холбоо
